



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/220.

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 17 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАОНӨГ/202312010 дугаартай Шинэ суурьшлын бүсийн цэцэрлэгт хүрээлэнгийн доторх тохижилт (Арвайхээр хотын 13 дугаар баг) ажлыг 240,000,000 (хоёр зуун дөчин сая) төгрөгөөр Өв аргуйт-Эрдэнэ, Огторгуйн бүтээл ХХК-иудын түншлэлээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0411

D:My Doc. Zahiramj. Zasag darga